

## ХАЛХЫН ГОЛЫН ДАЙН: ЯПОНЫ ТҮҮХ БИЧЛЭГТ

Д.Дашдулам

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим.

**Өгүүллийн товч утга:** Монгол улсын гадаад харилцааны болон улс төрийн түүх, цэргийн түүхийн судалгаанд Халхын голын дайны асуудал чухал байрыг эзэлдэг бөгөөд өнөө уед ч ач холбогдоо алдаагүй байгаа билээ. Уг асуудлыг судалсан Монгол, Орос, Японы судлаачид дайн үүссэн нөхцөл байдал, явц үр дүнгийн талаар одоо болтол өөр өөр байр суурьтай яваасар иржээ. Гэтэл Халхын голын дайны судалгаанд холбогдох судалгааны түүхэн баримтуудыг судалгааны эргэлтэнд оруулах, цаашид энэ талын судалгаанд судлаачдын анхаарлыг хандуулж өргөн цар хүрээнд хамтран судлах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгарч байна. Уг өгүүлэлд Халхын голын дайны талаарх Японы судлаачдын бүтээлүүдийн талаар цухас дурдахыг хичээлээ.

**Түлхүүр үгс:** Халхын голын дайн, квантуны арми, Аль Дорнод, ашиг сонирхол, хүчний харьцаа, улсын хил.

Дэлхий олон оронд Монголын түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж байгаа бөгөөд түүний дотроос Япон дахь Монголын түүх судлал томоохон байр суурийг эзэлдэг юм. Японы судлаачид Монголын түүхийн бүхий л үеэр судалгаа хийж олон тооны судалгааны бүтээлүүдийн хэвлүүсэн байдаг.

Би энэхүү илтгэлдээ Японы судлаачдын зөвхөн "Халхын голын дайн"-ы талаарх судалгааны талаар өгүүлэхийг хүсч байна.

Японд Халхын голын дайны талаарх судалгаа дайн дууссаны дараахнаас хийгдэж эхэлсэн байдаг. Квантуны армийн командлал (Кантогүн буюу Кантогийн арми 関東軍) -аас дайнд ялагдсан шалтгаан, сургамжийг тодруулах, армийн байлдааны бэлэн байдлыг сайжруулах талаар зохих арга хэмжээ авах зорилгоор "Номонханы будлианыг судлах хороо"-г байгуулжээ. Уг хороо нь ерөнхий цэргийн асуудлыг судлах 1-р комисс, тагнуул, нууц үйл ажиллагааг судлах 2-р комисс гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэж байжээ. Мөн нисэх хүчний удирдах төв газрын дэргэд "Номонханы будлианыг судлах агаарын төв хороо"-г нэгэн зэрэг шахуу байгуулжээ. Дээрх комиссуудын илтгэл Японы үндэсний батлан хамгаалах академийн номын санд хадгалагдаж байгаа бөгөөд миний бие уг илтгэлүүдийг уншиж танилцах завшаан олдсон юм. Уг илтгэлд байлдаан болсон газар орны шинж байдал, байлдах урлаг, цэргийн удирдлага, армийн уламжлалт сэтгэл зүйн шинж чанар, армийн хангарт, учирсан хохирол зэрэг олон зүйлүүдийг хамруулжээ. Комиссын зүгээс Японы армийн ялагдсан шалгаануудыг тодруулаад зогсохгүй армийн бүтцийг өөрчлөх, байлдах чадварыг дээшлүүлэх, мөханикуулах, артиллериийн алсын тусгалыг нэмэгдүүлэх, ойрын зайн байлдаанд тулалдах тактикийг боловсруулах зэрэг олон чухал санааг гаргасан байдаг. Мөн дайнд ялагдахад хүргэсэн гол шалтгаануудын нэгэнд "армийн оперативын хэлтэс хангалтгүй ажилласан" гэж үзжээ. Дээрх комиссыг байгуулж ажиллуулсан явдал нь энэ талын судалгааны эхлэл болсон гэж хэлж болох юм. Үүний дараа дараагаас судлаачид болон дайнд оролцогчдын дурсамжууд олноороо хэвлэгдэн гарах болжээ.

Японы түүх бичлэгт "Халхын голын дайн"-ыг "Номонханы хэрэг явдал" хэмээн бичдэг. Энэ талаар зохиогдсон томоохон бүтээлүүд 1960-1980 онуудад хэвлэгдэн гарсан байна. Тухайлбал: Гомикава "Номонхан" (1977 он), Иэнага Сабуроу "Номхон далайн дайн" (太平洋戦争) (1968 он), Цэргийн түүхийн хүрээлэнгээс гаргасан "Дайны түүх" цувралын "Квантуны арми" Японы түүх нэвтэрхий толийн 7 боть, (1978 он), Хандо Казутоши "Номонханы зүн" (1998 он), Накаяма Такаши "Квантуны арми" (関東軍) (2000 он) зэрэг бүтээлүүдэд цэргийн байлдааны урлаг талаас нь дайнд японы зэвсэгт хүчний бэлтгэл ямар байв,

хангарт, зохион байгуулалт, байлдах чадвар, алдаа дутагдал юу байсан талаар тодорхой тайлбарласан байдаг.

Мөн дээрх асуудлыг Японы гадаад бодлогын хүрээнд авч үзсэн бүтээлүүд нэлээд гарсан юм. Жишээлбэл: Ёши Хироши "Шёовагийн гадаад харилцааны түүх" (昭和外交史), Морияма Кохэи "Шёовагийн эзэн хаан" (昭和天皇), Ёошимура Мичио "Япон ба Орос" (日本とロシア), Китагава Широу "Номонхан-Манжго улсын гадаад яамны ажилтан асаны гэрчийн уг" (ノモンハン-元満州国外交官の証言), "Шёовагийн түүхийг нүдээр үзэгчийн өгүүлэх нь" 目撃者が語る昭和史 (8 боть, 1989 он) "Японы гадаад харилцааны түүхийн толь" (日本外交辞典) (1992 он) зэрэг олон бүтээлд Японоос Хятад, Орос, Манжго улсуудтай харилцах явцад монголын талаар явуулсан гадаад бодлогын талаарх олон сонирхолтой зүйлүүдийг бичсэн байдаг.

Эдгэр бүтээлүүд нь хэдийгээр түүхэн үйл явдлыг тодруулахад чухал сурвалж болдог хэдий ч "Халхын голын дайн"-ыг хилийн будлианаас болж үүссэн жижиг мөргөлдөөн, мөн Токио дахь жанжин штабын хяналтгүйгээр Квантуны армийнхны явуулсан орон нутгийн байлдааны ажиллагаа байсан хэмээн бичсэн байдаг нь ихээхэн түгээмэл юм. Мөн нилээд бүтээлүүдэд "Халхын голын дайн" үүссэн шалтгаануудын нэгэнд "улсын хил" гэдэг ойлголтыг япончууд мэддэггүй байсантай холбоотой гэж тайлбарласан байдаг нь ихээхэн учир дутагдалтай. Тэдний тайлбарласнаар, Япончуудын "улсын хил" гэдэг ойлголт нь газар тариалангаар амьдардаг ард түмний онцлог, зан төрхөөс нөхцөлдөж бий болсон. Япончууд нь амьдрах орчны хувьд монголчууд шиг тодорхой орон зайд өөр улсуудтай хиллэж хөрш зэргэлдээ оршиж ирсэн уламжлал өрөөсөө байгаагүй. Япончууд нь амьдрах орчны хувьд эрт үеэс далайгаар хүрээлэгдсэн тул улсын хил гэж өрөөсөө байгаагүй, харин байгалийн хил буюу далайн хил л байсан юм. Иймээс Халх голоор хил хуваагддаг гэсэн мэдээллийг үгүйсгэлгүй түүнд итгэлтэй хандах нь аргагүй юм хэмээсэн байдаг гэж тайлбарласан нь түгээмэл юм.

Мөн Алс Дорнодод нөлөөгөө тэлэх гэсэн ЗХУ, Японы ашиг сонирхлын зөрчилдөөний үр дагавар нь "Халхын голын дайн"-д хүргэснийг ихэнх судлаачдын бүтээлүүдэд "Номонханы хэрэг явдал", "Номонхан Бүрд овооны хилийн будлиан", "Орон нутгийн байлдаан" байсан гэж үйл явдлыг хэт жижигрүүлэн бичсэн байдаг.

Японы судлаачдын "дайн" гэсэн үгнээс болгоомжлон "хилийн будлиан", "хэрэг явдал" гэж бичсээр ирсэн нь ч учир шалтгаантай бизээ. Квантуны арми Монголын Дорнод хилийн орчим Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчинд бут цохигдон ялагдсан явдал нь Япон улс, япон үндэстний хувьд тун эмгэнэлтэй хэрэг болсон билээ. "Зөвлөлт Монголын дайчдын ялалт нь Японы ялагдашгүй гэсэн домгийг няцааж Японы түрэмгийлэгчидтэй тэмцсэн Азийн улс түмнийг зоригжуулсан юм". Энэ ялагдал нь Японоос Азиid хийж байсан түрэмгий дайны анхны ялагдал болоод зогсохгүй Алс дорнод дахь Зөвлөлтийн эсрэг бодлогоос түр боловч татгалзаж, Зөвлөлт улстай харилцах харилцаагаа өөрчлөхөд хүргэсэн юм. Мөн "Коминтерний эсрэг гэрээ"-нд нэгэн холбоотон болоод байсан Герман, Италийн өмнө тун ч "эвгүй байдал"-д орсон төдийгүй Германаас Японд хандах хандлагад ихээхэн өөрчлөлтийг оруулсан гэж үзэж болох юм.

Энэ дашрамд тэмдэглэн хэлэхэд, манай судлаачдын Халхын голын түүхийн судалгааны бүтээлүүдэд ч энэ түүхэн үйл явдлыг "Халхын голын дайн", "Халх голын дайн", "Халхын голын тулалдаан", "Халх голын тулалдаан" гэж бичсээр ирсэн бөгөөд нэр томъёоны хувьд нэгэн мөр болгох хэрэгтэй байгаа билээ. Ухаант өвөг дээдэс маань өөрийн газар нутгаа харийнханд алдахаас болгомжлон хэнбуугай нь ч ойлгохоор "Халхын" хэмээн тодотгон үр ач бидэндээ өвлүүлсэн. Судлаач миний бие энэ талын судалгаанд "Халхын голын дайн" хэмээн нэрлэж хэвшүүлэхийг санал болгож байна.

ХХ зуунд Монголын зэвсэгт хүчнээс явуулсан хамгийн томоохон байлдаан бол Халын голын дайн юм. Энэ дайнд Монгол-Зевлэлт, Япон-Манжийн талаас нийтдээ 130 гаруй мянган хүн оролцож хэд хэдэн үе шаттайгаар 4 сарын турш тулалдсан бөгөөд газар нутгийн хувьд 75-80 км урт, 25-30 км өргөн уудам газар нутгийг хамарчээ. Дайнд армийн бүх салбар нэгжүүд (саллаа, суман, хороо, дивиз, арми) оролцож, цэргийн бүх төрөл ангиуд (ялан, морьт, механиксан, танк, их буу, онгоц)-ын хүчээр марш, хориглох, тулгарах, урах, давших зэрэг байлдааны бүх тактикийг хэрэглэсэн байдал.

Ер нь дайнд оролцогч талуудын зэр зэвсэг, хүчний харьцаа, хохирлын талаарх мэдээ, баримт ихээхэн зөрөөтэй байсаар байгааг хэлэх хэрэгтэй. Тухайлбал: 1939 оны 7 дугаар сарын 2-5-нд болсон Баянцагааны тулалдаанд Японы талаас 38 мянган цэрэг офицер оролцсон гэж Монгол Зөвлөлтийн судлаачид үздэг бол Японы судлаачид 15-19 мянган цэрэг оролцсон гэж үздэг. Японы түүхч Я.Ушижима бичихдээ "... 7 дугаар сарын эхний 2 өдрийн тулалдаанд 19 мянган хүн оролцсон" гэсэн байдал.

Мөн Монгол Манжгогийн хооронд улсын хил тогтоох 4 талын хэлэлцээрийн явц, санал зөрөлдөөн, талуудын байр суурь болон асуудлыг Зөвлөлт-Японы хооронд эцслэн шийдвэрлэсэн олон учир шалтгааныг өнөөгийн байр сууринаас бодитойгоор үзэж, энэ талын судалгааг урагшуулах шаардлага бидний өмнө зүй ёсоор тавигдаж Японд "Халхын голын дайн"-ы талаар хэвлэгдэн гарсан бүтээлүүд харьцангуй олон байдаг бөгөөд үүнээс онцлон үзэж зөвхөн нэгэн бүтээлийн талаар сонирхуулъя гэж бодож байна.

Энэ нь Ш.Китагавагийн "Номонхан-Манжго улсын гадаад яамны ажилтан асаны гэрчийн үг" хэмээх бүтээл юм. Үүнийг онцлон үзэх хэд хэдэн шалгаан байгаа юм. Тухайлбал: Халхын голын дайны оршил болох Манжго-гийн талаас 1935 оны 12-р сараас эхлэн Монголын дорнод хил хязгаарыг зөрчсөн явдал буюу Булан дэрс, Адаг дулаан дахь хилийн будлиануудаас авахуулаад "Манжуурын хэлэлцээр" хийх болсон шалтгаан, явц, үе шат, 2 талын бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт, санал зөрөлдөөн, мөн хил тогтоох комиссын үйл ажиллагааны талаар тун дэлгэрэнгүй бичсэнээр барахгүй зарим чухал баримтуудыг хавсралтаар бүрэн эхээр нь оруулж өгсөнөөрөө түүний ач холбогдол үнэлж баршгүй юм. Китагава нь тухайн үед Манжго улсын Гадаад яамны ажилтны хувьд бодит байдлыг нүдээр үзэж, түүнд оролцож байсан явдал нь болсон зүйлийг бичиж үлдээх боломжийг олгожээ. Уг асуудлын талаар бичихдээ нэг талын байр суурь баримтлалгүй, Монголын талын баримтуудыг нэлээд оруулсан нь ихээхэн ач холбогдолтой юм. Ялангуяа Манжуурын хэлэлцээрт оролцогч Япон-Манжго-гийн төлөөлөгчдийн нэрс, хэлэлцээрийн явц, төгсгөл, мөн хил тогтоох гэрээнд оролцогчдын байр суурийг тодруулахад тус дөхөм болох олон зүйл зөвхөн энэ номонд байдгаараа ихээхэн онцлогтой юм. Манжуурын хэлэлцээрт оролцсон Япон-Манжго-гийн төлөөлөгчдийн нэрс, албан тушаалыг Монгол, Япон талын сурвалжуудад дурьдахдаа хүний нэрний дуудлагыг өөр өөрөөр, мөн нэг хүний нэрийг хоёр хүний нэр болгон алдаатай, ойлгомж муутай бичсэн байдал бөгөөд түүхийн энэ эздрэээтэй, эгзэгтэй үеийг тодруулахад энэхүү бүтээл нь чухал сурвалж болдгоороо давтагдашгүй юм.

Өнөөдөр түүхид биднээс дэлхийн аль ч орны судлаач, эрдэмтэдтэй санал бодлоо чөлөөтэй солилцох, мэтгэлзэх, харилцан ойлголцох замаар судалгаагаа өргөжүүлж, хамтран ажиллах шаардлага юу юунаас илүү чухал болоод байна.

"Халхын голын дайн"-ы асуудлыг авч үзэхдээ ялагч, ялагдагч орны байр сууринаас хандалгүйгээр түүхэн үнэнийг бодитоор үнэлэн дүгнэж, түүхийн судалгааг урагшуулан хөгжүүлэх хэрэгцээ шаардлага орчин үед улам бүр өсөн нэмэгдэж байна. Хэдийгээр "Халхын голын дайн" дууссанаас хойш даруй 66 жил өнгөрөөд байгаа хэдий ч дайны сургамж, ач холбогдол улам бүр өсөж, Монгол,

Орос, Японы эрдэмтэн судлаачдыг судалгаагаа нягт уялдуудан гүнзгийрүүлэхийг цаг үе биднээс шаардаж байна.

**Abstract:** One of the significant roles in Mongol studies belongs to Japanese historians. Studies of the Battle at Khalkha river by Japanese scholars started soon after its completion. The author of this article makes a brief comment on standings of Japanese scholars concerning the cause and circumstances of this historic event. In particular, there are still differences among Mongolians and Japanese in determining the size of the conflict and forces involved.

#### Ном зүй

1. Японы Ундэсний батлан хамгаалах академийн номын сан
2. "Японы нэвтэрхий том толь", 1968, 11-р боть, 120 дахь тал
3. "Японы орчин цагийн түүхийн толь", 1658, 498 дахь тал
4. Ц.Пунцагноров, "Халх голын ялалт, түүний олон улсын ач холбогдол", "Дорно дахины судлалын асуудал" 1984, №2, 28 дахь тал
5. Ушижима Ясучика, "Номонханы бүрэн түүх" Токио, 1998
6. Китагава Широу, "Номонхан-Манжго улсын гадаад яамны ажилтан асаны гэрчийн уг", Токио, 1979